



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 3 сарын 14 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд оролцогчид
хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн
этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өмгөөллийн Легал Полиси” ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Өмгөөллийн Легал Полиси” ХХН /Б.Даваажанцан/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН